



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 11 сарын 21 өдөр

Дугаар A/62.

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын  
газрын үйл ажиллагаа  
эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ Нь:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэнд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай сунгасугай.

4. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын дөрөвдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.


5. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

6. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА





Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 20/4 оны 11 сарын 21 өдрийн

*А/62* тоот тушаалын нэгдүгээр хавсралт

YOA6453


ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ  
ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ

2014.11.21

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Дэлгэрэх цадиг ХХК	Фанат	Баянгол дүүрэг, 16-р хороо, Амарсанаагийн гудамж 43
2	Одод ХХК	Вояж	Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, СУИС-ын баруун хойно
3	Одод ХХК	Вояж	Баянгол дүүрэг, 3-р хороо, Нарны зам - 60
4	Богд-Өөд ХХК	Өлзий	Баянгол дүүрэг, 15-р хороо, Ард Аюушийн өргөн чөлөө
5	Зол халиун соронз ХХК	Соронз	Багануур дүүрэг, 4-р хороо, Жаргалантын 1/1

-ооОоо-



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 20.. оны ... сарын 20. өдрийн

A/62 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

УОА0453


ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ  
ОЛГОХ ИРГЭНИЙ НЭРСИЙН ЖАГСААЛТ

2014.11.21

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Ц.Цэцэгбадам	Сэнжит Оюу	Баянгол дүүрэг, 20-р хороо, Дэвшлийн урд задгайд

-ооОоо-



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2014. оны 11. сарын 11. өдрийн  
*A/сай* тоот тушаалын гуравдугаар хавсралт


ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ  
СУНГАХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ

2014.11.21

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Таац алт ХХК	Таац	Баянгол дүүрэг, 22-р хороо, Зүүн нарангийн 18 дугаар гудамж 70
2	Мандах хөлөг ХХК	Тавлаг	Баянгол дүүрэг, 12-р хороо, Хасбаатар бк тоот
3	Иргэн С.Саруултуяа	Зэд	Баянгол дүүрэг, 17-р хороо, 4-р хороолол, Дамдинбазарын гудамж 7/1 тоот

-ооОо-



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
дэргэн 2014 оны 11 сарын 21 өдрийн  
Аж ахуйн нэгжийн нэршилтэй тушаалтын дөрөвдүгээр хавсралт

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙГ  
ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ

2014.11.21

Улаанбаатар хот

Д/ð	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Мөнх-Үрс ХХК	Хан тэрэлж	Налайх дүүрэг, 6-р хороо, ОНГОЦТЫН АМ

-ооОо-